



**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2020 оны 03 сарын 30 өдөр

Дугаар А/133

Арвайхээр


Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.3-ийн "а", Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. 2019-2020 оны отроор өөр аймаг, сумын нутаг дэвсгэрт өвөлжиж, хаваржиж байгаа малчдад төрийн үйлчилгээг тухайн сумдаас нь хүргүүлэх зорилгоор Төв аймгийн Цээл сумын Засаг даргын Тамгын газарт 1.500.000 (нэг сая таван зуун мянга) төгрөг, Булган аймгийн Гурванбулаг сумын Засаг даргын Тамгын газарт 3.000.000 (гурван сая) төгрөг, бүгд 4.500.000 (дөрвөн сая таван зуун мянган) төгрөг, эмийн багцад 9.770.100 (есөн сая долоон зуун далан мянга нэг зуун) төгрөгийг тус тус зарцуулсугай.

2. Дээрх арга хэмжээнд шаардлагатай 14.270.100 (арван дөрвөн сая хоёр зуун далан мянга нэг зуу) төгрөгийг Гамшгаас хамгаалах, эрсдэлийг бууруулах арга хэмжээний зардлаас гаргахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, Төрийн сангийн хэлтэс (Д.Нэмэхбаяр)-т зөвшөөрсүгэй

ЗАСАГ ДАРГА



Г.ГАНБОЛД

011100285